

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
	2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
	2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.12. Шилэн дансны мэдээлэл	8
	2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
	3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
	3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
	3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
	3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
	3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.01 № 06/337
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төслийн зохицуулагч А.Мөнхтайван Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 46 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 төслийг хэрэгжүүлэх МОН-

2963 зээлийн гэрээ байгуулсан бөгөөд 2013 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Төслийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлээр 30,000.0 мянган ам.доллар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын буцалтгүй тусламжаар 480.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн газар 7,709.1 мянган ам.долларыг тус тус санхүүжүүлнэ.

Төслийн зорилго:

Монгол Улсын эмнэлгээр үйлчлүүлэгч өвчтөнүүд, тэнд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнуудын аюулгүй байдлыг сайжруулах.

Төслийн зорилтууд:

1. Цус сэлбэлтийн үеийн аюулгүй байдлыг бэхжүүлэх,
2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах
3. Эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах

Төслийн үйл ажиллагаа:

Төслийн 2019 онд хэрэгжүүлэхээр баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 93.3 хувьтай хэрэгжсэн байна.

Төслийн бүрэлдэхүүн 3-ын хүрээнд 2019 оны 6 дугаар сард ЭХЭМҮТ, ХСҮТ, ГССҮТ, Өвөрхангай, Дорнод аймгийн БОЭТ, Баянхонгор, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийн барилгын засвар хийх, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, сургалт явуулах үйл ажиллагаа нэмэгдсэн байна.

Цусны донорын мэдлэг хандлага дадлын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх чиглэлээр иргэдийн мэдлэг хандлагыг судлан, мэдээлэл, үйлчилгээний хэрэгцээг судлах, эмнэлгийн халдвар хамгааллын чиглэлээр эмнэлгийн ажиллагсадын мэдлэг хандлагыг судлан, мэдээлэл, үйлчилгээний хэрэгцээг судлах, хог хаягдлын менежментийн, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг судлах зэрэг судалгаанууд хийгдэж байгаа бөгөөд суурь судалгааг 2015 онд, давтан судалгааг 2018 оны 9 сараас эхлэн хийгдэж байна.

Архитектур, зургийн компани нийт 25 цусны салбар банк, 19 ариутгалын төв тасаг, 20 микробиологийн лабораторийн барилгын засварын зураг, төсвийг гүйцэтгэсэн байна. Эрүүл мэндийн яамнаас шинээр хийгдэх 8 эмнэлгийн ариутгалын тасгийн засварын гэрээний өөрчлөлтүүд хийгдэхээр төлөвлөж байгаа ба дууссан барилга засварын ажлуудыг Улсын комисс хүлээж авах ажил үргэлжилж байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл нь санхүү, нягтлан бодох

бүртгэлийн үйл ажиллагаанд “Ритус” программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 18,422,907.5 мянган төгрөгөөс тооцон 184,229.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 166,249.2 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,521,727.0 мянган төгрөгөөр буюу 92 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардлын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,253,234.1	2,612,969.6	(14,640,264.5)
Авлага	17,455.8	18,054.2	598.4
Урьдчилж гарсан зардал тооцоо	16,857,022.9	-	(16,857,022.9)
Үндсэн хөрөнгө	41,973.3	16,935.3	(25,038.0)
Нийт хөрөнгийн дүн	34,169,686.1	2,647,959.0	(31,521,727.0)
Богино хугацаат өр төлбөр	2,110,500.0	442,995.1	(1,667,504.9)
Хуримтлагдсан үр дүн	32,059,186.1	2,204,963.9	(29,854,222.2)
Нийт өр төлбөр, Өмчийн дүн	34,169,686.1	2,647,959.0	(31,521,727.0)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд тоног төхөөрөмж, их засварын ажлын гүйцэтгэлээр гэрээний дагуу төлбөр тооцоо хийгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь ханшийн зэрүү 598.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдэл буурсан нь 13,377,658.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, 3,479,364.1 мянган төгрөгийн засварын ажил бүрэн дууссан тул тайланд оны зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансдын үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдлийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал 25,038.0 мянган төгрөгөөр хуримтлагдсан элэгдлийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны эхний үлдэгдэл "G7 шинэ" дугаарын Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвд лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний үлдэгдэл төлбөр 2,110,500.0 мянган төгрөгийг Сетунари ХХК-д төлсөнөөр буурч, тайлант онд хийгдсэн барилгын засварын ажлын гүйцэтгэл 442,995.1 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч, өглөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 18,422,907.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 2,072,907.5 мянган төгрөгийг зээл, 69,500.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, хөрөнгийн зардалд 16,350,000.0 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээр санхүүжүүлэн зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Зээлийн санхүүжилт-Урсгал зардал	2,072,907.5	1,948,077.9	124,829.6	94.0
Зээлийн санхүүжилт-Хөрөнгө оруулалт	16,350,000.0	-	16,350,000.0	-
Улсын төсвийн санхүүжилт	69,500.0	60,787.7	8,712.3	87.5
Нийт дүн	18,492,407.5	2,008,865.6	16,483,541.9	10.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгийн зардалд 16,350,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 15,125,691.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлыг АХБ-ны шууд төлбөрөөр 411,506.7 мянган төгрөг, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 14,714,185.0 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Урсгал зардалд 2,072,907.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,499,227.0 мянган төгрөгийг зарцуулж нийт төсвийн гүйцэтгэл 573,680.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл тодорхойлж, нийт 12 горим сорилын хэрэгжүүлээ.

Аудитаар 2 асуудлаар нийт 677,097.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залруулан тайлагнасан. Үүнд:

1. Барилгын их засварын ажлын худалдан авалтын гэрээ батлагдсан ч 2019 онд ажил хүлээлцсэн акт батлагдаагүй учир төлбөр хийгдээгүй 186,132.4 мянган төгрөгийн тооцоог санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардал, бусад өглөг дансанд бүртгэж тайлагнасан.
2. Тоног төхөөрөмжийн худалдан авалтын гэрээ батлагдсан ч 2019 онд урьдчилгаа төлбөр хийх хүсэлт батлагдаагүй учир төлбөр хийгдээгүй 490,965.1 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардал, бусад өглөг дансад бүртгэж тайлагнасан байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар худалдан авалтын хэрэгжилтийг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 181 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	17,253,234,086.16	2,612,969,576.71
Төрийн сангийн харилцах данс	56,981,811.08	843,625,334.36
Валютын харилцах тусгай данс	17,196,252,275.08	1,769,344,242.35
АВЛАГА	17,455,825.87	18,054,216.22
Бусад авлага	17,455,825.87	18,054,216.22
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ ТООЦОО	16,857,022,870.99	
Урьдчилж гарсан зардал /тоног төхөөрөмж/	13,377,658,761.47	-
Урьдчилж гарсан зардал /дуусаагүй барилга/	3,479,364,109.52	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,127,712,783.02	2,631,023,792.93
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	41,973,283.99	16,935,255.76
Авто тээврийн хэрэгсэл	119,500,000.00	119,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(89,625,000.00)	(109,541,666.67)
Машин, тоног төхөөрөмж	36,776,194.22	36,776,194.22
Хуримтлагдсан элэгдэл	(31,113,661.58)	(34,666,272.24)
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,687,509.00	15,687,509.00
Хуримтлагдсан элэгдэл	(9,251,757.65)	(10,820,508.55)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,973,283.99	16,935,255.76
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,169,686,067.01	2,647,959,048.69
Богино хугацаат өр төлбөр	2,110,500,000.00	442,995,141.39
Бусад өглөг	2,110,500,000.00	442,995,141.39
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,110,500,000.00	442,995,141.39
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,110,500,000.00	442,995,141.39
ЭЗНИЙ ӨМЧ		
Хуримтлагдсан үр дүн	32,059,186,067.01	2,204,963,907.30
Өмнөх үеийн үр дүн	622,303,534.75	32,059,186,067.01
Тайлант үеийн үр дүн	31,436,882,532.26	(29,854,222,159.71)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	32,059,186,067.01	2,204,963,907.30
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	34,169,686,067.01	2,647,959,048.69

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	37,351,854,709.00	1,948,132,523.26
Зээлийн санхүүжилтийн орлого	37,351,854,709.00	1,536,625,762.51
Зээлийн шууд санхүүжилтийн орлого	-	411,506,760.75
Улсын төвлөрсөн төсвөөс	36,494,000.00	69,500,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,494,000.00	69,500,000.00
Бараа ажил үйлчилгээний орлого	27,773,626.97	52,225,353.54
Хүүгийн орлого	27,773,626.97	52,225,353.54
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	37,416,122,335.97	2,069,857,876.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Ажиллагчидтай холбоотой зардал	31,521,176.04	575,096,618.82
Цалин	-	514,308,863.32
Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,521,176.04	60,787,755.50
Бусад бараа үйлчилгээний зардал	1,357,658,948.94	949,223,009.70
Бичиг хэргийн зардал	9,075,700.00	3,099,900.00
Тээвэр, шатахуун, сэлбэгийн зардал	6,172,900.00	7,336,600.00
Шуудан, холбоо, интернэтийн зардал	5,691,476.12	3,757,677.00
Дотоод томилолтын зардал	22,817,099.00	24,575,900.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	626,173.00	551,585.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг зардал	580,119,320.65	679,545,281.73
Бараа үйлчилгээний бусад зардал	708,118,251.94	205,318,037.74
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,038,028.23	25,038,028.23
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,664,278,561.62	30,315,209,685.55
Их засвар	154,833,653.00	6,006,068,822.83
Тоног төхөөрөмж	4,509,444,908.62	24,309,140,862.72
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	6,053,458,686.60	31,839,529,314.07
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,362,663,649.37	(29,769,671,437.27)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	85,892,887.02	598,390.35
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	85,892,887.02	598,390.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	4,084,460.17	24,211,514.75
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,084,460.17	24,211,514.75
Төвлөрүүлэх шилжүүлэг	7,589,543.96	60,937,598.04
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	31,436,882,532.26	(29,854,222,159.71)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Татаас санхүүжилтийн орлого	37,351,854,709.00	1,948,077,905.06
Зээлийн санхүүжилтийн орлого	37,351,854,709.00	1,948,077,905.06
Улсын төвлөрсөн төсвөөс	36,494,000.00	69,500,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,494,000.00	69,500,000.00
Бараа, ажил үйлчилгээний орлого	27,773,626.97	52,225,353.54
Хүүгийн орлого	27,773,626.97	52,225,353.54
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	37,416,122,335.97	2,069,803,258.60
Ажиллагчидтай холбоотой зардал	307,476,843.04	60,787,755.50
Цалин	275,955,667.00	-
Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,521,176.04	60,787,755.50
Хангамж, бараа материалын зардал	20,940,076.12	14,194,177.00
Бичиг хэрэг	9,075,700.00	3,099,900.00
Тээвэр, шатахуун	6,172,900.00	7,336,600.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,691,476.12	3,757,677.00
Томиллт, зочны зардал	21,050,671.00	25,127,485.00
Дотоод албан томиллт	20,424,498.00	24,575,900.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	626,173.00	551,585.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	303,396,810.25	1,193,799,519.25
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	303,396,810.25	1,193,799,519.25
Бараа үйлчилгээний бусад зардал	715,707,795.90	266,255,635.78
Бараа үйлчилгээний бусад зардал	708,118,251.94	205,318,037.74
Төвлөрүүлэх шилжүүлэг	7,589,543.96	60,937,598.04
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,368,572,196.31	1,560,164,572.53
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	36,047,550,139.66	509,638,686.07
Их засвар	(3,634,197,762.52)	(2,083,709,571.92)
Тоног төхөөрөмж	(15,776,603,670.09)	(13,041,982,108.85)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(19,410,801,432.61)	(15,125,691,680.77)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	81,308,203.62	11,229,705.70
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,084,460.17	35,441,220.45
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	77,223,743.45	(24,211,514.75)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	539,261,635.66	17,253,234,086.16
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,253,234,086.16	2,612,969,576.71

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	622,303,534.75	622,303,534.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			622,303,534.75	622,303,534.75
Тайлант үеийн үр дүн			31,436,882,532.26	31,436,882,532.26
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	32,059,186,067.01	32,059,186,067.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			32,059,186,067.01	32,059,186,067.01
Хөрөнгийн үнэлгээний өсөлт, бууралт				-
Тайлант үеийн үр дүн			(29,854,222,159.71)	(29,854,222,159.71)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	2,204,963,907.30	2,204,963,907.30

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,422,907,500.00	16,624,918,655.26	1,797,988,844.74	90.2
2	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,072,907,500.00	1,499,226,974.49	573,680,525.51	72.3
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,072,907,500.00	1,499,226,974.49	573,680,525.51	72.3
4	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,500,000.00	60,787,755.50	8,712,244.50	87.5
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,500,000.00	60,787,755.50	8,712,244.50	87.5
6	Хангамж, бараа материалын зардал	53,140,000.00	14,194,177.00	38,945,823.00	26.7
7	Бичиг хэргийн зардал	31,200,000.00	3,099,900.00	28,100,100.00	9.9
8	Тээвэр, шатахууны зардал	15,600,000.00	7,336,600.00	8,263,400.00	47.0
9	Шуудан холбооны зардал	6,340,000.00	3,757,677.00	2,582,323.00	59.3
10	Томилолт, зочны зардал	41,820,000.00	25,127,485.00	16,692,515.00	60.1
11	Дотоод албан томилолт	39,420,000.00	24,575,900.00	14,844,100.00	62.3
12	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,400,000.00	551,585.00	1,848,415.00	23.0
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,619,447,500.00	1,193,799,519.25	425,647,980.75	73.7
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,619,447,500.00	1,193,799,519.25	425,647,980.75	73.7
15	Бараа үйлчилгээний бусад зардал	289,000,000.00	205,318,037.74	83,681,962.26	71.0
16	Бараа, үйлчилгээний бусад зардал	289,000,000.00	205,318,037.74	83,681,962.26	71.0
17	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	16,350,000,000.00	15,125,691,680.77	1,224,308,319.23	92.5
18	Их засвар	2,850,000,000.00	2,083,709,571.92	766,290,428.08	73.1
19	Тоног төхөөрөмж	13,500,000,000.00	13,041,982,108.85	458,017,891.15	96.6
20	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,422,907,500.00	2,008,865,660.56	16,414,041,839.44	10.9
21	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-	0.00	
22	Бусад орлого			0.00	
23	Эх үүсвэрээс санхүүжих	18,422,907,500.00	2,008,865,660.56	16,414,041,839.44	10.9
24	Зээлийн санхүүжилт	18,353,407,500.00	1,948,077,905.06	16,405,329,594.94	10.6
25	Улсын төсвөөс санхүүжих	69,500,000.00	60,787,755.50	8,712,244.50	
26	Тохируулгын дүн		(24,211,514.75)		
27	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	17,253,234,086.16		
28	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,612,969,576.71		
29	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
30	Байгууллагын тоо	1			
31	Ажиллагсдын тоо	10			
32	Удирдах ажилтан	1			
33	Гүйцэтгэх ажилтан	9			

